

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024.12.02

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2024 онд хэрэгжүүлсэн Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021-2024 оны үйл ажиллагааны Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд болон тус байгууллагаас дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдлыг хамруулж үр дүнг үнэлэв.

НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮНЭЛГЭЭ

1.1.ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2024 онд 4 эрх зүйн актын 18 зүйл заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажилласан.


Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд өгсөн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Зорилт	Зүйл, заалтийн тоо	Хэрэгжилтэд өгсөн үнэлгээ			
			/-/	30	70	90- 100
1	Монгол Улсын хууль	6	-	-	-	6
2	Ерөнхийлөгчийн зарлиг	1	-	-	-	1
3	Засгийн газрын тогтоол	7	-	-	-	7
4	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	4	-	-	-	4
Нийт		18	-	-	-	18

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт “бүрэн хэрэгжсэн” буюу 99.8 хувьтай үнэлэгдэв.

Өмнөх оны үнэлгээтэй харьцуулбал:

2023 он	2024 он	Өсөлт, бууралт
100%	99.8	-0.2%



1.2.МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан 5.3.”Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлнэ” зорилтын хүрээнд дөрвөн арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажилласан.

Үнэлгээг хүснэгтээр харуулбал:

Зорилт	Арга хэмжээ ний тоо	Гүйцэтгэлийн хувь							Дундаж	
		/-/	0	30	50	70	90	100	хувь	оноо
5.3. мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлнэ:	4	-	-	-	-	-	-	4	100	5.0

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл хэрэгжилт “үр дүнтэй” буюу 100 хувиар үнэлэгдэв.

1.3. ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний Засаглалын бодлого хэсгийн 4.1.1.”Төрийн байгууллагын мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлж, “Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна”, 4.2.1. “Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно”, 4.2.5. “Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана” гэсэн 3 зорилтод хамаарах 7 арга хэмжээг хяналтад авч, тэдгээрийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Хяналтад авсан 8 арга хэмжээний биелэлтэд өгсөн үнэлгээг хүснэгтэд харуулав:


№	Зорилт	Арга хэмжээний	Хэрэгжилтэд өгсөн үнэлгээ						Дундаж Хувь
			0	30	50	70	90	100	
1	4.1.1.Төрийн байгууллагын мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлж,	5	-	-	-	2	-	3	88.0

	"Нэг иргэн-нэг бүртгэл" арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна.							
2	4.2.1. Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.	1					1	100.0
3	4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	1					1	100.0
НИЙТ		7				2	5	91.4

Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан УБЕГ-ын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт "Тодорхой үр дүнд хүрсэн" буюу **91.4** хувьтай үнэлэгдэв.

Өмнөх оны үнэлгээтэй харьцуулбал:

2023 он	2024 он	Өсөлт, бууралт
100%	91.4%	(-8.6)%



1.4.УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Алсын хараа 2050", Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн А/150 дугаар тушаалаар батлуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан 26 арга хэмжээг дараах байдлаар хэрэгжүүлэн ажилласан.

Арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ							Дундаж Хувь
	/-/	0	30	50	70	90	100	
26	-	-	1	1	1	1	22	93.8

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт “тодорхой үр дүнд хүрсэн” буюу **93.8** хувиар үнэлэгдэв.

Хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

№	Арга хэмжээ	Биелэлт	Үнэлгээ
	1.1.Улсын бүртгэлийн ерөнхий газар, орон нутаг дахь улсын бүртгэлийн газар, хэлтсийг үе шаттайгаар архив, үйлчилгээний байртай болгох.	Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилга угсралтын ажлыг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо УБЕГ-ын даргын 2024 оны А/39 тоот тушаалаар байгуулагдсан. Барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд барилгын суурьт тулсан айлыг нүүлгэн газрыг шилжүүлэн Нийслэлийн Засаг даргын 2024.05.03-ны өдрийн А/498 дугаар захирамжаар газар эзэмших эрхийн 0000284276 дугаартай гэрчилгээг авсан. Мөн ВВБМО ХХК-тай 2024.09.06-ны өдөр 2024/64 тоот гэрээг байгуулан хамтран ажиллан, Барилгын хөгжлийн төвийн барилга байгууламжийн дүгнэлт 2024.11.18-ны өдөр баталгаажиж, нийт төсөвт өртөг 6,4 тэрбум төгрөгөөр баталсан. Барилга угсралтын ажлыг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлтийг хуулийн хугацаагаар 2024.12.13-ны өдөр нээж дүгнэлт, мэдэгдлийг хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	50
	2.6.Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн санд холбох	МУ-ын Ерөнхий сайдын 2024 оны 60 дугаар захирамжаар "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай" Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэ, салбар хоорондын холбогдох үйл ажиллагааг уялдуулах ажлыг зохион байгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд нарийн бичгийн даргаар УБЕГ-ын дарга ажиллаж байна. Тус ажлын хэсгийн анхдугаар хурал 2024.11.22-ны өдөр зохион байгуулагдаж, УБЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Болдхүү болон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга Б.Ариунболд нар оролцож "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг Улсын бүртгэлийн ерөнхий газартай холболт хийж дундын мэдээллийн санг байгуулах ажлын талаарх танилцуулга"-ыг хийсэн. УБЕГ, ГЗБГЗЗГ-ын даргын хамтарсан 2022.05.31-ний өдрийн А/118, А/462 дугаар тушаалаар байгуулагдсан Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг нь 2024.11.20-ны өдрийн байдлаар 4 удаа уулзалтыг зохион байгуулсан. Тус уулзалтуудаар газрын кадастрын мэдээллийн системд өмчлөлийн газрын бүртгэл мэдээллийг	70

		түүхчилсэн байдлаар хөрвүүлэх, эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв бүртгэхэд бүртгэлийн байгууллагаас гарах өгөгдөл мэдээллийг авах замыг тодорхойлж, мэдээлэл солилцохоор Үндэсний дата төвд байрлах баазад газрын үйлчилгээний түүхчилсэн мэдээллийн сервисийг үүсгэж, ГЗБГЗЗЕГ-аас авах хаягийн мэдээллийн багануудыг тодорхойлж хүргүүлсэн. Мөн хаягийн санг нэгтэх зорилгоор улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь кадастрын дугааргүй бүртгэлийг нөхөж оруулах ажлын явц 2024.11.25-ны өдрийн байдлаар нийт 128,783 нэгж талбарын дугаар буюу нийт нөхөж оруулах шаардлагатай бүртгэлийн 62.7 хувийг нөхөн оруулаад байна. Эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл 2024.11.25-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 7,666 хаяг өөрчлөгдсөн бүртгэл хийгдсэн байна.	
3	5.1.Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх	Байгууллагын хүний нөөцийн хөгжлийг тодорхойлох, албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, удирдах ажилтны манлайлах ур чадварыг төлөвшүүлэх, хөгжүүлэх, ажилтан, албан хаагчид болон удирдах албан тушаалтнуудын харилцаа холбоог бэхжүүлэх, албан хаагчдыг давтан мэргэшүүлэн сургах, чадавхжуулах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад чиглэн судалгааг хийн “Улсын бүртгэлийн ерөнхий газрын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн төслийг боловсруулан Даргын зөвлөлийн хурлаар оруулж батлуулах бэлтгэл ажлыг хангасан.	30

1.5.САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 55 дугаар “Яамдын эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийг батлах тухай” тогтоолын 5 дугаар хавсралтад заасан Улсын бүртгэлийн ерөнхий газарт хамаарах 2 үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг 100 хувь буюу 5.0 оноогоор дүгнэв.

№	Үзүүлэлт	Зорилтот түвшин 2024 он	Гүйцэтгэл 2024 он	Үнэлгээ
1	Цахим хэлбэрт шилжүүлсэн хуулийн этгээдийн хувийн хэргийн тоо	251,772	251,772	100%
2	Цахим хэлбэрт шилжүүлсэн эд хөрөнгийн хувийн хэргийн тоо	1,362,313	1,362,313	

ХОЁР.БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ 2.1.БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 43 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 92.55 хувийн биелэлттэй байна.

Үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Зорилт	Зүйл, заалт ийн тоо	Хэрэгжилтэд өгсөн үнэлгээ						Дундаж Хувь
			/-/	30	50	70	90	100	
1	Зорилт 1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.	8	-	-	1	-	-	7	93.75%
2	Зорилт 2. Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.	8	-	1	-	1	1	5	86.25%
3	Зорилт 3. Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.	14	-	-	-	1	-	13	97.85%
4	Зорилт 4. Гадаад улстай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	2	-	-	-	-	-	2	100%
5	Зорилт 5. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.	5	-	1	1	1	-	2	70%
6	Зорилт 6. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.	3	-	-	-	-	-	3	100%
7	Зорилт 7. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.	3	-	-	-	-	-	3	100%
Нийт		43	-	2	2	3	1	35	92.55%


Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

№	Арга хэмжээ	Хувь
1	1.1. Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилгыг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах	50
2	2.3. Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгох ажлыг үе шаттайгаар эхлүүлэх /blockchain/	30
3	2.6. Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан байгуулах, өөрчлөлт оруулах, хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх	70
4	3.2. Хуулийн этгээдийг мөнгө угаах_терроризмыг санхүүжүүлэхэд ашиглахтай холбоотой эрсдэлийн үнэлгээ шинэчлэх	70
5	5.2. Гадаадын төсөл, хөтөлбөр, ижил түвшний бүртгэлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ, санамж бичгийг тухай бүр боловсруулж, хэрэгжүүлэх.	50
6	5.3. Бүртгэлийн системд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийг шинэчлэн, нөөцийг бүрдүүлэх	70
8	5.5. Эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн системийг шинэчлэх ажлыг эхлүүлэх	30

Өмнөх оны үнэлгээтэй харьцуулбал:

(Тайланг аравдугаар хавсралтаас үзнэ үү.)

2023 он	2024 он	Өсөлт, бууралт
92.96%	92.55%	-0.41%



2.2.ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР, 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024.11.12-ны өдрийн А/180 дугаар тушаалын хавсралтаар “Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”, 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүллээ.


Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлбэл:

№	Арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь					Дундаж хувь
		/-/	30	50	70	100	
1	14	-	-	-		14	100

Өмнөх оны үнэлгээтэй харьцуулбал:

2023 он	2024 он	Өсөлт, бууралт /+, -/
98%	100%	2

(Биелэлтийг арваннэгдүгээр хавсралтаас үзнэ үү.)



ГУРАВ .БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ 3.1.БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтад заасан 45 шалгуур үзүүлэлт /үйл ажиллагааны ил тод байдлын 10, хүний нөөцийн ил тод байдлын 6, төсөв санхүүгийн 15, үйлчилгээний 1, бусад 13/-ийн дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийв.


Үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Шалгуур үзүүлэлт	Арга хэмжээний тоо	Үнэлгээ /хувиар/
1	Үйл ажиллагааны ил тод байдал	10	100.0
2	Хүний нөөцийн ил тод байдал	6	83.3
3	Төсөв санхүүгийн ил тод байдал	15	99.3
4	Үйлчилгээний ил тод байдал	1	100.0

5	Бусад	13	100.0
Нийт дундаж		45	96.7

Өмнөх оны үнэлгээтэй харьцуулбал:

2023 он	2024 он	Өсөлт, бууралт
100.0%	96.7%	-3.3




3.2.ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд сар тутам хяналт тавьж, улирал тутам Хууль зүй, дотоод хэргийн яаманд мэдээг хүргүүлж ажиллав. Мэдээлэл байршуулах давтамжийн хугацаагаар тооцож үзэхэд 2024 оны эхний 11 сарын байдлаар Төсвийн байгууллагын мэдээлэл байршуулах нэгж 23 төрлийн мэдээг давтамжтайгаар 149 удаа, Төвлөрүүлэн захирагчийн мэдээлэл байршуулах 1 нэгж 19 төрлийн мэдээг давтамжтайгаар 118 удаа буюу системийн хэмжээнд нийт 3,694 мэдээллийг мэдээлсэн.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээ байршуулалт 100.0 хувь байна.

Өмнөх оны үнэлгээтэй харьцуулбал:

Тайлант он	Жилийн дундаж хувь	Оноо
2023 он	99.05%	4.95
2024 он	100%	5



Шилэн дансны цахим хуудсанд:

-Төсвийн гүйцэтгэлийн 11 төрлийн мэдээлэл;

-Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5 төрлийн мэдээлэл;

-Бусад 7 төрлийн мэдээллийг тус тус байршуулсан.

Өмнөх жилийн мөн үеэс өссөн хэдий ч салбарын хэмжээнд нийт 6 мэдээллийг цахим системд хугацаа хоцроон байршуулсан үзүүлэлттэй байна. Цаашид цахим системд хугацаа хоцроон байршуулахгүй байх талаар урьдчилан анхааруулах арга хэмжээ авч хуулийн хугацаанд бүрэн байршуулж мэдээлэхээр ажиллаж байна. (Биелэлтийг арвандөрөвдүгээр хавсралтаас үзнэ үү.)

3.3.ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ

Авлигын эсрэг үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Авлигатай тэмцэх газраас сонгон шалгаруулсан "Бодлогын шийдэл" ТББ-аас Шударга байдлын үнэлгээг 2024 оны 7,8,9 дүгээр сард УБЕГ-т хийгдсэн болно. Үнэлгээний нэгдсэн тайланг Авлигатай тэмцэх газраас 2025 оны эхний улиралд нийтэд мэдээлэхээр хариу ирүүлсэн. Мөн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2025.01.5-ний өдөр Авлигатай тэмцэх газарт хуваарийн дагуу хүргүүлж үнэлгээ хийгдэнэ.

3.4.ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2024.09.11-ээс 2024.11.11-ны хооронд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хамруулан 690 иргэн, хуулийн этгээдийг хамруулан “Гранд дата” ХХК-аар хийж гүйцэтгүүлсэн.

Үнэлгээг үйлчилгээний чанар, үйлчилгээний хүртээмж, үйлчилгээний ажилтны харилцаа, ёс зүй, байгууллагын орчин нөхцөл гэсэн 4 багц үзүүлэлтээр үнэлж, ерөнхий үнэлгээ 87.8 хувь, 4.39 оноогоор дүгнэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар өссөн үзүүлэлттэй тайланг ирүүлсэн.

“Хэрэглэгчийн үнэлгээ”-ний судалгааг Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг хамруулан 690 иргэн, хуулийн этгээдийг хамруулан судалсан. Тус судалгааг иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл гэсэн 3 чиглэлд хийсэн. Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны хэрэглэгчийн үнэлгээний судалгааны үр дүнд тулгуурлан санал зөвлөмжийг ирүүлснийг үйл ажиллагаандаа тусган анхаарч, ирэх оны төлөвлөгөөнд холбогдох арга хэмжээг тусган авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ОНЦЛОХ АЖЛУУД

4.1.2024 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД

Улсын бүртгэлийн ерөнхий газар 2024 онд дараах онцлох ажлуудыг хийж гүйцэтгэв:

1. Албан хаагчдын ажиллах орчныг сайжруулав.

1.Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн байрны их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны А/03 тоот тушаалаар байгуулагдан “Өгөөмөр уул” ХХК-тай ХЗДХЯ/20240101023, 24 тоот гэрээ байгуулсан бөгөөд 2024.08.25-ны өдрийн байдлаар гэрээний гүйцэтгэл 100 хувь хангагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

2.Говь-Алтай аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн үйлчилгээний заалыг өргөтгөх ажлыг 2024.03 сард хийж үйлчилгээний танхимыг өргөтгөж, улсын бүртгэгчдийн сургалтын өрөөг шинээр тохижуулж гадаад паспортын зураг авах өрөөг шинэчилсэн.

3.Сэлэнгэ аймгийн улсын бүртгэлийн хэлтэс Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн “Сэлэнгэ аймгийн тодотгосон төсөв батлах тухай” 180 дугаар тогтоол, аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээнд тусгагдсаны дагуу 15,000,000 сая төгрөгийг шийдвэрлүүлэн Нутгийн захиргааны 3 дугаар байранд байрлаж буй хэлтсийн байранд 2,3 дугаар давхрын шал болон санхүү хариуцсан ажилтны өрөөний засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.

2. Иргэний үнэмлэхэд ойрын зайнаас мэдээлэл солилцох технологи /NFC/-ийг нэвтрүүлэв.

Монгол Улсын иргэний цахим үнэмлэхэд ойрын зайнаас мэдээлэл солилцох /NFC/ технологийг нэвтрүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Монгол Улсын иргэний үнэмлэхийн тодорхойлолт загварыг шинэчлэн батлах тухай” 374 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт 2024.01.31-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, мөн өдрийн 52 дугаар тогтоолоор батлуулсан.

Иргэний үнэмлэхэд NFC технологийг ашиглан мэдээлэл унших программ хангамжийн хөгжүүлэлтийн ажлыг хийж дууссан бөгөөд 2024 оны 1 дүгээр сараас хэвлэлт хийж эхэлсэн шинэ бэлдцийн апплет хувилбарыг 5.0.2 болгосон. Ингэснээр NFC технологийг

ашиглах бүрэн боломжтой болсон тул банкнууд болон хамтрагч байгууллагуудад иргэний үнэмлэх уншдаг “dll” гарган өгч, байгууллагын цахим хуудаст гарын авлага байршуулсан.

3. Иргэний цахим үнэмлэхийн бичилтийн үйлдвэрийг өргөтгөв.

Иргэний үнэмлэхийн бичилтийн үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардлагатай Иргэний үнэмлэхийн машин, дагалдах тоног төхөөрөмж, системийн тооцоо судалгааг хийж, техникийн даалгаврыг 2024 оны 1 дүгээр сард боловсруулан бичилтийн үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардлагатай Иргэний үнэмлэхийн машин, дагалдах тоног төхөөрөмж, систем худалдан авах тендерийн урилгыг 2024.01.18-ны өдөр www.tender.gov.mn, www.burtgel.gov.mn сайтад тус тус байршуулж, “Смарт карт” ХХК-ийн тендер шаардлагад нийцсэн тендерээр шалгарсан “Смарт карт” ХХК-тай 2024/34 тоот гэрээ байгуулав. Гэрээнд тусгагдсан тоног төхөөрөмж, программ хангамжийг УБЕГ-ын даргын 2024 оны А/57 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2024.04.19-ний өдрийн 01 дугаартай актаар хүлээн авсан. Иргэний үнэмлэхэд бичилт хийх тоног төхөөрөмж, модуль хоорондын холболтын ажлыг 2024.04.22-ноос эхлүүлж, 2024.04.26-ны өдөр туршилтын ажлыг хийж, 21 аймаг 35,442, нийслэлийн 9 дүүрэг, үйлчилгээний нэгдсэн төв, нэг цэгийн үйлчилгээ 188,053, e-mongolia 32,914, элчин сайдын яамаар дамжин ирсэн 5,951 нийт 262,360 иргэний цахим үнэмлэх хэвлэн, хүргүүлсэн.

4. Улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх цахим машин /Киоск/, зөөврийн төхөөрөмжийн тоог нэмэгдүүлэв.

Улсын бүртгэлийн цахим үйлчилгээний 104 ширхэг киоск машиныг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлж, шаардлагатай нэгжүүдэд хуваарилж, ашиглалтад оруулан анхан шатны нэгжүүдэд байршуулан, 29 төрлийн лавлагаа, үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

-Лавлагаа-20 /Иргэний улсын бүртгэл-12, Хуулийн этгээдийн улсын бүртгэл-6, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл-2/

-Үйлчилгээ-9 /Иргэний улсын бүртгэл-4, Хуулийн этгээдийн улсын бүртгэл-2, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл-3/

УБЕГ-аас үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдлыг хангах ажлын хүрээнд бүртгэлийн үйлчилгээг биеэр болон цахим хэлбэрээр авах боломжгүй иргэдэд зориулж бүртгэлийн зөөврийн үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөн ажилласан. Энэхүү ажлын хүрээнд өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, алслагдсан газарт оршин суугч, хүнд өвчтэй иргэн, цэргийн анги, асрамжийн газар, хорих байгууллагад байгаа иргэдэд хүрч дараах үйлчилгээг үзүүлэхээр зорин ажиллав. Үүнд:

- иргэний улсын бүртгэлийн 10,
- хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 8,
- эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 9 төрлийн лавлагаа, үйлчилгээ үзүүлж байна.

Тайлант хугацаанд манай байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй, зорилтод бүлгийн иргэний хүсэлтийн дагуу оршин суугаа хаяг, Монголын Хараагүйчүүдийн Үндэсний холбоо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, уул уурхайн кемп, эмнэлэг, ерөнхий боловсролын сургуулиудад зөөврийн буюу хөдөлгөөнт үйлчилгээг зохион байгуулж 18,833 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэв.

5. Гадаад паспорт захиалгын өөртөө үйлчлэх бүрэн автомат машиныг суурилуулав.

УБЕГ-ын 24/7 төв, Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс, Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс, Улаанбаатар төмөр замын вокзал, Өмнөговь аймгийн Ханбогд сумын “Гашуун сухайт” боомт, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын “Бичигт” боомтод тус тус гадаад паспорт захиалгын өөртөө

үйлчлэх бүрэн автомат 7 КИОСК машиныг суурилуулан 5,550 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

6. Улсын бүртгэлийн үйлчилгээг тасралтгүй үзүүлэх 24/7 цэгтэй болов.

Улсын бүртгэлийн чанар, шуурхай байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 1 дүгээр давхарт, Нийслэлийн Баянзүрх дүүрэг, Багануур дүүрэг, Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дэргэд, Дүнжингарав ННҮТ, Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Орхон, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Баянхонгор, Баян-Өлгий, Завхан, Дундговь, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Увс, Сэлэнгэ, Төв, аймгийн Засаг даргын тамгын газарт байрлах Цахим төвд, улсын бүртгэлийн “Цахим үйлчилгээний 24/7 төв”-г тус тус нээж ашиглалтад оруулаад байна.

7. E-Mongolia, E-business төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэв.

Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /e-mongolia, e-business/-д нийт 123 лавлагаа, үйлчилгээг шилжүүлээд байна. Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 13, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 7, нийт 20 (давхардсан тоогоор) үйлчилгээг шинээр нэвтрүүлэв. Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-Mongolia/, /E-business/-аар үзүүлж байгаа бөгөөд нийт 18,075,802 лавлагаа, үйлчилгээг олгосон

8. Барьцааны гэрээг цахимаар бүртгэх системийг хэрэглээнд нэвтрүүлэв.

Барьцааны гэрээг цахимаар бүртгэх ажлыг үйлчилгээнд нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байгаа ба энэ хүрээнд Худалдаа хөгжлийн банк, Капитрон банк болон МИК ОССК ХХК-ийн системийн хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлснээс хойш барьцааны гэрээний дуусгавар болгох үйлчилгээний мэдүүлгийг цахимаар хүлээн авч боловсруулах системийг 2024.03.01-ний өдөр хэрэглээнд нэвтрүүлснээс хойш 2024.11.20-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр нийт 5,052 мэдүүлэг хүлээн авч боловсруулсан байна.

9. Хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газруудыг нууцлал бүхий сүлжээ /VPN/-д холбов.

Гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх зорилгоор хилийн чанадад ажиллаж байгаа ДТГ-т VPN сүлжээ тавих шийдлийг гаргаж, холбогдох лиценз, программ хангамжийг бэлэн болгон 2024.05.11-ний өдрөөс 2024.05.29-ний өдрийг хүртэл хугацаанд Тагнуулын байгууллагын зөвлөмж, чиглэлийг хүргүүлж, хилийн чанадад ажиллаж байгаа нийт 32 ДТГ-ын бүртгэлийн ажилтны тоног төхөөрөмжийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд холбож /VPN/ сонгогчийн бүртгэлийн тоног төхөөрөмж, программ хангамжийг хүлээлгэн өгч ажилласан. Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд холбосон ДТГ нийт 45 байна.

10. ЭМЯ-тай хамтран дундын мэдээллийн сан ашиглан нас барсны бүртгэл хөтөлж эхлүүлсэн.

Улсын бүртгэлийн мэдээлэл солилцоо болон дундын мэдээллийн сангийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ЭМЯ-ны нас барсны санг үндэслэн нас барсны бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүртгэх ажлыг 2024.04.16-ны өдөр эхлүүлж 2024.11.25-ны өдрийн байдлаар 5,751 иргэнийг ЭМЯ-ны нас барсны дундын санд бүртгэсэн байна. Энэ нь бүртгэлийн мэдээллийг үнэн зөв хөтөлж, бүртгэлийн алдаа багассан ба нас барсны бүртгэлийн тоон мэдээлэл зөрүүгүй гарах боломжийг бүрдүүлсэн.

11. МУИХ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллав.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд УБЕГ-ын даргын 2023.11.06-ны өдрийн А/1712 тоот тушаалаар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг”-ийг байгуулагдан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг Сонгуулийн ерөнхий хорооны 2024.01.09-ний өдрийн 01 тоот тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарь”-т нийцүүлэн боловсруулж, 6 дэд ажлын хүрээнд нийт 112 ажил хийхээр төлөвлөсөн. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувь хангасан тухай тайланг 2024.07.08-ны өдрийн 1/9174 тоот албан бичгээр ХЗДХСайдад хүргүүлсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг 5 бүлэг бүхий 71 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан.

12. Монгол Улсад анх удаа сонгуулийн ирц бүртгэлийн тоног төхөөрөмжийг сүлжээнд холбож, цахимаар ирцийн мэдээг шууд харах ажлыг амжилттай хийж гүйцэтгэв.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.17 дахь хэсэгт “Сонгогчдын нэрийн жагсаалт цаасан болон цахим хэлбэртэй нэгдсэн нэг сантай байх...” гэсэн хуулийн заалт 2023.06.16-ны өдөр хуульд өөрчлөлт оруулснаар манай байгууллагад сонгогчдын ирц бүртгэлийн программ хангамжийг сайжруулах өөрчлөлт оруулах, сонгуулийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа зөөврийн компьютерыг бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбох, сүлжээний аюулгүй байдлыг хангах шаардлага тулгарсан.

Тус байгууллага нь Засгийн газрын 2022 оны 197, 207 дугаар тогтоолоор Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон болон Онц чухал дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад багтсан, суурь мэдээллийн сан бүхий байгууллага тул бүртгэлийн нэгдсэн сүлжээнд утасгүй холболт хийх төгсгөлийн тоног төхөөрөмжийг мэдээллийн сан, сүлжээний аюулгүй байдлыг хангасан, 24 цагийн турш тасралтгүй ажиллах горимтой, бүртгэлийн байгууллагын дотооддоо ашигладаг гадны халдлагаас хамгаалах системтэй нийцэж ажиллах гэх шаардлагын үндэслэн судалгаа, туршилтын ажлыг ТЕГ-ын хяналт доор хийж гүйцэтгэсэн.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн өдөр 2,198 сонгуулийн хэсгийн хороонд 2000 ш үүрэн телефоны сим уншдаг модем / модем 4G /, 179ш старлинк буюу алсын зайн сүлжээ баригч модемыг ашигласнаар Монгол Улсад анх удаа сонгуулийн ирц бүртгэлийн тоног төхөөрөмжийг сүлжээнд холбож, сүлжээний аюулгүй байдлыг ханган, цахимаар мэдээ дамжуулах, нэг зэрэг системд хандах ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн.

13. Байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулав.

Улсын бүртгэлийн Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батлуулсан. Үүнд:

1.УБЕГ-ын дарга, ТЕГ-ын даргын хамтарсан “Журам, маягт, загвар батлах тухай” 2024 оны А/11, А/22 дугаартай тушаалын хавсралтаар “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал зөрчлийг арилгах, танилцуулах, сонгогч шилжих журам, маягт, загвар”-ыг баталсан.(Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6699 дугаарт бүртгэгдсэн.)

2.УБЕГ-ын даргын “Журам батлах тухай” 2024 оны А/25 дугаартай тушаалын хавсралтаар “Гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, хүргүүлэх журам”-ыг батлуулан, “Журамд өөрчлөлт оруулах тухай” 2024 оны А/64 дугаартай тушаалаар өөрчлөлт оруулсан. (Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6701 дугаарт бүртгэгдсэн бөгөөд захиргааны хэм хэмжээний актын өөрчлөлтөд нөлөөллийн шинжилгээг хийж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд хөдөлгөөн хийлгэсэн.)

3.УБЕГ-ын дарга, ТЕГ-ын даргын хамтарсан “Журам батлах тухай” 2024 оны А/12, А/23 дугаартай тушаалын хавсралтаар “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах, ашиглах журам”-ыг баталсан. (Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6700 дугаарт бүртгэгдсэн.)

4.“Улсын бүртгэлийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг 2024.04.25-ны өдрийн Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, УБЕГ-ын даргын 2024 оны А/63 дугаар тушаалын хавсралтаар батлуулсан.

14. Сум, хорооноос хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх улсын бүртгэгч нарын тоог нэмэгдүүлэв.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид шилжүүлэх ажлыг зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд байгууллагын даргын 2024.05.15-ны өдрийн Б/297 дугаартай тушаалаар нийт 19 аймгийн эрх зүйч мэргэжилтэй 115 сумын улсын бүртгэгчид эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх, 197 сумын улсын бүртгэгчид хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрхийг тус тус олгосноор нийт 312 улсын бүртгэгч суманд бүртгэл хөтлөх эрхтэй болсон. Тайлант хугацаанд суманд эд хөрөнгийн эрхийн улсын 26,057, хуулийн этгээдийн эрхийн улсын 7,938 (нэр баталгаажуулалт 3543, хуулийн этгээдийн бүртгэл 4395) бүртгэлийг тус тус хөтөлсөн байна.

15. Монгол Улсын Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж байгаа “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг хэрэгжүүлэв.

Монгол Улсын Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж байгаа “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг хэрэгжүүлэх, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор зөөврийн тоног төхөөрөмжөөр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ тэр дундаа хоршооны нэр баталгаажуулах, улсын бүртгэлд бүртгэх үйлчилгээг үзүүлэх зорилгоор 6 албан хаагчдыг томилон ажиллуулж 592 хуулийн этгээдийн нэр баталгаажуулж, 252 хуулийн этгээдийн бүртгэл хөтөлсөн байна.Үүнд:

4.2.ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

УБЕГ-ын 2024 оны үйл ажиллагааны үр дүнг харуулбал:

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо /5-с/
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	99.8	0.5	4.81
	2.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	91.4		
	3.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлт	100.0		
	4.УБЕГ-ын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний биелэлт	93.8		
	5.Салбарын хөгжлийн үзүүлэлт	100.0		

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	92.5	0.2	
	2.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	100.0		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод нээлттэй байдлын үнэлгээ	96.7	0.3	
	2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	100		
	3.Шударга байдлын түвшний үнэлгээ	-		
	4.Хэрэглэгчийн үнэлгээ	87.8		
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ		96.1	1.0	

УБЕГ-ын 2024 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн 96.1 хувь буюу 4.8 оноотой дүгнэгдсэн нь 2023 оны үнэлгээнээс 1.4 хувиар буурсан үзүүлэлт юм.

Цаашид бууралттай арга хэмжээний хүрээнд тодорхой ажил зохион байгуулж, төлөвлөлтөд анхаарч, гүйцэтгэлийг бүрэн хангуулж ажиллах болно.

--oOo--